

НЭХЭМЖЛЭХ БА ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ БОДЛОГО

1. БОДЛОГО:

- НордШоор их сургуулийн Эрүүл мэндийн систем (НордШоор гэх) нь НордШоороор үйлчлүүлдэг, тухайн харьяа газарт орших суух хувь хүмүүс, өрхүүдийн хэрэгцээг хангахуйц чанартай, үр дүнтэй эрүүл мэндийн асаргаа, тусламж үйлчилгээ, эрүүл мэндтэй холбоотой бусад үйлчилгээг үзүүлэх зорилготой. Энэхүү бодлогыг хэрэгжүүлэхийн тулд НордШоор дараах ашгийн бус эмнэлгүүдийг эгнээндээ хамруулдаг. Үүнд: Эванстон Эмнэлэг, Гленбрүүк эмнэлэг, Хайлэнд парк эмнэлэг, Скоки эмнэлэг болон Шведийн эмнэлэг ба Нордвестийн олон нийтийн эмнэлэг болон Нордвестийн олон нийтийн өдрийн мэс заслын төв II (хамтдаа, NCH) зэрэг багтана. NCH болон Шведийн эмнэлгийн хувьд бодлого нь ялгаатай байдаг бөгөөд бодлогын ялгаатай байдлыг тус тусад нь тодорхойлно.
- Энэхүү бодлогоор НордШоорын өвчтөнүүдэд үзүүлсэн үйлчилгээнүүдтэй холбогдуулан төлбөртэй үйлчилгээний төлбөр ба эмч нарын төлбөрийг барагдуулахын тулд НордШоорын зүгээс авах арга хэмжээнүүдийг тодорхойлов. Тус бодлогоор мөн төлбөр барагдуулахтай холбоотой үйл явц ба цаг хугацаа, төлбөрийг төлөөгүй нөхцөлд НордШоорын зүгээс авч болох арга хэмжээ, болон өвчтөн санхүүгийн туслалцаа авах шаардлагыг хангаж буй эсэхийг тогтоохын тулд НордШоорын зүгээс авч хэрэгжүүлж болох бодитой хүчин чармайлтуудыг тодорхойлжээ.
- Энэхүү бодлогод НордШоороос үзүүлсэн үйлчилгээний төлбөрийн төлөгдөөгүй нийт дүнтэй холбогдуулан НордШоорын зүгээс өвчтөнүүдтэй хэрхэн харилцах харилцааны талаар тусгана.
- Энэхүү бодлогоор мөн НордШоорын зүгээс өвчтөний тооцоог найдваргүй авлагад тооцох нөхцөлүүд болон өвчтөний тооцоонуудын хасах бичилтийг хянах үйл явцыг тодорхойлно.
- Дотоод Орлогын Кодын 501(г) хэсэгт заасан Төлбөр барагдуулалтын онцгой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхгүй.
- Энд дурдсан бодлого, үйл ажиллагаа нь Иллинойс муж улсын дүрэм журмууд, Дотоод Орлогын Кодын 501(г) хэсэг болон холбогдох удирдамжид нийцсэн болно.
- НордШоорын аж ахуйн алба Шведийн Эмнэлгийн Санхүүгийн үйлчилгээний төв болон NCH-н Өвчтөнд Үйлчлэх Төв нь санхүүгийн туслалцаа авах шаардлагыг хангасан болохыг тодорхойлоход НордШоорын зүгээс хангалттай хүчин чармайлт гаргасан эсэхийг тогтоох, шийдвэрлэх эрхтэй байна.

2. ХАМРАХ ХҮРЭЭ:

Энэхүү бодлого нь НордШоорын өвчтөнүүдэд үзүүлсэн үйлчилгээнүүдийн төлбөртэй үйлчилгээний ба эмч нарын төлбөрийн үлдэгдэл, тооцоонуудад хамаарна.

3. ТОДОРХОЙЛОЛТУУД:

Хүсэлт – гэж өвчтөний бөглөх санхүүгийн туслалцаа авах тухай хүсэлтийг ойлгоно.

Хүсэлтийн хугацаа – Хүсэлтийн хугацааны туршид НордШоор санхүүгийн туслалцааны хүсэлтийг хүлээн авч, боловсруулна. Хүсэлтийн хугацаа хувь хүнд асаргаа үйлчилгээг үзүүлсэн өдрөөс эхэлж үзүүлсэн асаргаа үйлчилгээний эхний нэхэмжлэх ирсэн өдрөөс хойш 240 дэх хоног дээр дуусна.

Найдваргүй авлагаас хасах – Төлж барагдуулахааргүй, барагдуулах боломжгүй хэмээн тооцсон төлбөрийн дүнгийн хувьд өвчтөний тооцоог найдваргүй авлагаас хасдаг боловч өвчтөн үлдэгдэл төлбөрийг төлөх үүрэгтэй байна. Төлбөр барагдуулах тогтсон шалгуур үзүүлэлтийг ашиглан энэхүү тодорхойлолтыг гаргах бөгөөд зөвхөн төлбөр тооцоотой холбогдуулан нэхэмжлэх гаргаж, төлбөр барагдуулах дараа дараачийн зохих арга хэмжээг авч хэрэгжүүлсний дараа л ийнхүү тооцооноос хасна.

Гэрээний залруулга – гэж үйлчилгээний тогтсон дүнгээр тооцож гаргасан өвчтөний нийт төлбөр ба гэрээний зохицуулалт болон бодлогын дагуу гуравдагч этгээдээс ирүүлэх бодит нөхөн төлбөрийн зөрүүг тусгахын тулд өвчтөний тооцоонд оруулах залруулга, тохируулах бичилтийг ойлгоно.

Төлбөр барагдуулалтын онцгой арга хэмжээ (ТБОУХ) – Эдгээр нь хууль эрх зүйн эсвэл шүүхийн үйл явц шаардсан болон өр төлбөрийг өөр этгээдэд зарах эсвэл зээл олгох байгууллагууд эсвэл товчоодод сөрөг мэдээлэл мэдэгдэх гэх мэт бусад үйл ажиллагааг хамарсан төлбөр барагдуулах үйл ажиллагаанууд юм. НордШоорын зүгээс ийм Төлбөр барагдуулалтын онцгой арга хэмжээнүүдэд оролцдоггүй бөгөөд төлбөр барагдуулах ажилтнууддаа ч Төлбөр барагдуулалтын онцгой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхийг зөвшөөрдөггүй.

Санхүүгийн туслалцаа – Санхүүгийн туслалцаа гэдэг нь НордШоорын Санхүүгийн туслалцааны бодлогод (СТБ) тодорхойлсноор санхүүгийн болон бусад төрлийн туслалцааг авах эрхийн шалгуур үзүүлэлтийг хангасан хүмүүст эмнэлгийн байгууламж дотор НордШоорын зүгээс үзүүлсэн чухал шаардлагатай болон яаралтай эрүүл мэнд асаргааны тусламж үйлчилгээний төлбөрийг төлөхөд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг олж авахад нь туслах зорилгоор НордШоороос санал болгодог туслалцаа юм. Шаардлага хангасан өвчтөнүүд гэдэгт даатгалгүй өвчтөнүүд, бага орлоготой өвчтөнүүд, хэсэгчилсэн даатгалтай боловч эмчилгээний зардлынхаа зарим хэсгийг эсвэл бүхэлд нь төлөх чадваргүй өвчтөнүүд багтана.

Энгийн хэл найруулгаар бичсэн хураангуй – НордШоорын СТБ-ын энгийн хэл найруулгаар бичсэн хураангуйд: 1) тавигдах шаардлагууд болон санал болгосон туслалцааны товч тодорхойлолт; 2) санхүүгийн туслалцаа авах хүсэлтийг авч болох вэбсайт болон газруудын байршлын жагсаалт; 3) СТБ-ын хэвлэмэл хувийг хэрхэн үнэ төлбөргүй авах зааварчилгаа; 4) хүсэлт гаргах явцад шаардлагатай туслалцааг авахад шаардагдах холбоо барих мэдээлэл; 5) СТБ болон холбогдох бичиг баримтуудыг ямар ямар хэлээр орчуулсан талаарх мэдээлэл; болон 6) санхүүгийн туслалцаа авах эрхтэй хэмээн тодорхойлогдсон өвчтөнд яаралтай тусламжийн эсвэл эмнэлгийн шаардлагатай үйлчилгээнд нэхэмжилсэн ерөнхий дүнгээс (НЕРД) хэтрэхгүй дүнгээр төлбөр тооцохыг баталгаажуулсан мэдэгдэл багтана.

Хангалттай хүчин чармайлт – НордШоор СТБ-ын энгийн хэл найруулгаар бичсэн хураангуйг өвчтөнд санал болгож, НордШоорын СТБ-ын талаар тодорхой мэдээлэл хүргэхийн тулд хангалттай хүчин чармайлт гарган ажиллана. Мөн түүнчлэн өвчтөнүүдэд НордШоорын СТБ-ын талаар ойлголт өгөхийн тулд дараах алхмуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- 1) Хүсэлтийг дутуу бөглөх - Хэрэв өвчтөн ба/эсвэл өвчтөний гэр бүлийн гишүүн санхүүгийн туслалцааны хүсэлтийг бүрэн бус, дутуу бөглөж өгвөл, НордШоор ямар ямар нэмэлт мэдээлэл, бичиг баримт хэрэгтэйг тодорхойлсон мэдэгдлийг бичгээр гаргаж өгнө.
- 2) Хүсэлтийг бүрэн бөглөх – Хэрэв өвчтөн ба/эсвэл өвчтөний гэр бүлийн гишүүн санхүүгийн туслалцааны хүсэлтийг бүрэн бөглөж өгвөл, НордШоор тухайн өвчтөн санхүүгийн туслалцаа авах эрхтэй эсэхийг тодорхойлох мэдэгдлийг цаг тухайд нь бичгээр гарган өгч, тухайн өвчтөнд энэ шийдвэр (мөн боломжтой бол, тухайн өвчтөний авч болох туслалцааны тухай) болон шийдвэрийг гаргасан үндэслэлээ бичгээр мэдэгдэнэ. Уг мэдэгдэлд мөн санхүүгийн туслалцааны хувиар тооцсон дүн (зөвшөөрөгдсөн хүсэлтийн хувьд) эсвэл татгалзсан шалтгаан болон өвчтөн ба гэр бүлээс нь төлөх төлбөрийн дүнг оруулна. Өвчтөн ба/эсвэл гэр бүл нь бүрэн бөглөсөн хүсэлтийг дүгнэх явцад мэдэгдэл хүлээн авсаар байна.
- 3) Өвчтөнд мэдэгдэл ирүүлэх – НордШоорын зүгээс өвчтөнд тухайн өвчтөний тооцоо ба төлөх ёстой дүнг дурдсан хэд хэдэн мэдэгдлийг илгээнэ. Өвчтөнд ирүүлэх мэдэгдэлд тухайн өвчтөн өөрийн хамрагдсан аливаа эрүүл мэндийн даатгалын талаарх мэдээллийг НордШоорт мэдэгдэх үүрэгтэйг сануулсан бичиг, НордШоорын СТБ-ын талаарх мэдэгдэл, санхүүгийн туслалцаа хүсэх утасны дугаар болон санхүүгийн туслалцаа хүсэхэд шаардагдах бичиг баримтуудыг авч болох вэбсайтын хаягууд багтана.
- 4) НордШоорын вэбсайт – НордШоор вэбсайтаа санхүүгийн туслалцаа авах боломжтой талаарх мэдээллийг санхүүгийн туслалцаа хүсэх үйл явцын талаарх тайлбарын хамт харагдахуйц газар байрлуулна. НордШоор нь www.northshore.org/about-us/billing/financial-assistance эсвэл www.swedishcovenant.org/for-patients-and-visitors/pay-your-bill/financial-assistance or www.nch.org/billing-insurance/financial-assistance/ вэбсайтуудад өөрийн СТБ-ыг СТБ-д хамрагдсан болон хамрагдаагүй үйлчилгээ үзүүлэгчдийн жагсаалт, энгийн хэл найруулгаар бичсэн хураангуй, санхүүгийн туслалцааны хүсэлт болон нэхэмжлэх ба төлбөр барагдуулалтын бодлогын хамт нийтэлнэ. Эдгээр бичиг баримтуудыг хүсэлт гаргасны үндсэн дээр хэвлэмэл байдлаар нь НордШоорын яаралтай тусламжийн тасаг, бүртгэлийн хэсгээс, эсвэл Шведийн эмнэлгийн хувьд (847) 570-5000 ба (773) 989-3841, NCH-н хувьд (847) 618-4542 дугаарын утсаар холбогдож авах боломжтой.

4. ҮЙЛ АЖИЛЛАГАА:

- A. *Өвчтөнтэй харилцах*: Орлогын циклийн аль болох эхээр өвчтөнүүдэд тэдний төлбөрийн төлөгдөөгүй үлдэгдэл, мөн НордШоорын төлбөрийн төлөвлөгөөтэй холбогдох мэдэгдлийг бичгээр эсвэл аман хэлбэрээр ирүүлнэ. Өвчтөнтэй харилцах бүх харилцаанд санхүүгийн туслалцааны хүргэмжтэй байдлын талаарх мэдэгдэл, нэмэлт мэдээлэл авах утасны дугаар болон санхүүгийн туслалцааны бичиг баримтуудын хуулбарыг авч болох вебсайтын хаягууд зэргийг багтаана. Мөн НордШоорын зүгээс СТБ-ын энгийн хэл найруулгаар бичсэн хураангуйг бүх өвчтөндөө санал болгоно.
- B. *Санхүүгийн туслалцаа*: Боломжит гуравдагч этгээдийн эх үүсвэрээс нөхөн төлбөрийг гаргуулахад нь өвчтөнд туслах явдал бол НордШоорын тогтсон заншил юм. Өвчтөнүүдийн холбооны эсвэл муж улсын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хамрагдах боломжтой хөтөлбөрийг тогтоох, мөн НордШоорын СТБ-д хамрагдах эрхтэй эсэхийг тодорхойлоход нь туслах зорилгоор өвчтөнүүдэд санхүүгийн зөвлөгөө өгдөг. Эдгээр тодорхойлолтын үр дүн гарах хүртэл төлбөр барагдуулалтын үйл ажиллагааг түр зогсоох боловч өвчтөний мэдүүлгийг үргэлжлүүлэн илгээх болно. НордШоороор дамжуулан санхүүгийн туслалцаа авахын тулд хөнгөлөлтийн дүнг тооцоодоо ашигладаг шалгуур үзүүлэлтүүд, НордШоорын зүгээс НордШоорын үйлчилгээ үзүүлдэг харьяа газарт СТБ-ыг олон нийтэд өргөнөөр сурталчлахын тулд авдаг арга хэмжээнүүд, санхүүгийн туслалцаа авах эрхтэй эсэхийг тогтоохын тулд НордШоорын авч хэрэгжүүлдэг үйл явц болон хүсэлт гаргах үйл явцын талаар **Санхүүгийн туслалцааны бодлогод** дэлгэрэнгүй тайлбарласан болно.
- C. *Төлбөрийн төлөвлөгөө*: НордШоор нь төлбөр тооцоогоо төлөхөд хүндрэлтэй байгаа өвчтөнүүдэд хүүгүй, уртасгасан хугацаатай төлбөрийн төлөвлөгөөг санал болгодог.
- D. *Төлбөр төлөөгүй нөхцөлд тооцоо барагдуулах үйл ажиллагаа*: Төлбөр төлөөгүй нөхцөлд, тооцооны үлдэгдэл, гуравдагч этгээд төлбөр төлөгчийн нөхөн төлөх үүрэг хариуцлага, өвчтөний засгийн газраас тэтгэмж эсвэл санхүүгийн туслалцаа авах боломж, эрх, өвчтөний хамтран ажиллаж буй байдал, өр төлбөрийн ба найдваргүй зээлийн түүх, мөн өвчтөнийг тогтоох боломжгүй байдал зэрэгт үндэслэн төлбөр барагдуулалтын янз бүрийн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Төлбөр барагдуулалтын үйл ажиллагаанд гуравдагч этгээд төлбөр төлөгчийн төлбөр төлөхөөс татгалзсан гомдол, гуравдагч этгээд төлбөр төлөгчтэй харилцах дэс дараалсан харилцаа, санхүүгийн туслалцааг үзүүлж, төлбөр төлөхийг хүссэн өвчтөнд өгсөн мэдэгдэл, захидал, утасны дуудлага, болон өвчтөн төлбөр тооцооны үлдэгдэлтэй бөгөөд өвчтөний төлөх ёстой дүнгийн талаар өвчтөнд мэдэгдсэн анхны мэдэгдлээс хойш 120 хоногоос хэтрэхгүй хугацаанд төлбөр барагдуулалтын албанд байршуулах ёстой талаар өвчтөнд мэдэгдэх эцсийн мэдэгдэл зэрэг үйл явц багтаж болно. Мөн төлбөр тооцоог барагдуулаагүй хугацаа хэтрүүлсэн гуравдагч этгээдийн эсрэг НордШоорын зүгээс хууль ёсны арга хэмжээг авч болно.
- E. *Найдваргүй авлага*: Төлбөр тооцооны нэхэмжлэхийг боломжит гуравдагч этгээд төлбөр төлөгч болон өвчтөн/батлан даагч руу илгээж, төлбөр тооцооны дүнг тогтоож, дараа дараачийн харилцаа үүсэж, санхүүгийн туслалцааны хүргэмжтэй байдлын талаар өвчтөнд мэдэгдэхийн тулд хангалттай хүчин чармайлт гаргаж, төлбөрийн хугацаа дуусаж, төлбөр тооцоо төлөгдөх боломжгүй хэмээн тогтоогдсоны дараа л тооцоог найдваргүй авлагын данснаас хасаж болно. Төлөгдөх боломжгүй гэж тогтоогдсон төлбөр тооцоонуудыг НордШоорын төлбөр тооцооны алба болон Шведийн эмнэлгийн Санхүүгийн үйлчилгээний төв болон NCH-н Өвчтөнд Үйлчлэх Төвд тогтмол хугацаагаар хүргүүлдэг бөгөөд гуравдагч этгээд төлбөр барагдуулалтын албанд шилжүүлэх ажлыг түргэсгэхийн тулд цаг тухайд нь хасахыг зөвшөөрнө.
- F. *Хөндлөнгийн төлбөр барагдуулалтын үйл ажиллагаанууд*: Зөвхөн бүрэн гүйцэт нэхэмжлэх гаргаж, төлбөр барагдуулахын тулд хөндлөнгийн байгууллагад хандах гэх мэтээр төлбөр барагдуулах арга хэмжээг зохих түвшинд хийж гүйцэтгэсний дараа л зөвхөн зохих тооцоонуудыг найдваргүй өрнөөс хасахын тулд Санхүүгийн үйлчилгээний баг өвчтөний найдваргүй авлагын хасах бичилтийг хянаж, багтуулна. Тогтсон төлбөр барагдуулалтын шалгуур ба батлагдсан хасах бичилтийг зөвшөөрөх хязгаарт тулгуурлан, НордШоорын төлбөр тооцооны алба, Шведийн эмнэлгийн Санхүүгийн үйлчилгээний төв болон NCH-н Өвчтөнд Үйлчлэх Төв хасах бичилтийг баглах, эсвэл зохих үйл ажиллагааг санал болгохын аль нэгийг сонгож, шийдвэрийг гаргана. (Тогтсон төлбөр төлөгч, үлдэгдэл ба төлбөрийн үйл ажиллагааны үзүүлэлтүүдэд тулгуурлан өвчтөний тооцооны системээр төлбөр тооцоог төлбөр барагдуулалтын хөндлөнгийн байгууллага руу автоматаар шилжүүлдэг).
- G. *Хэрэгжилт*: Энэхүү бодлогын хэрэгжилтийг хангах, хэлтсийн үйл ажиллагааны дүрэм журмыг гаргах ажлыг НордШоорын төлбөр тооцооны алба, Шведийн эмнэлгийн Санхүүгийн үйлчилгээний төв болон NCH-н Өвчтөнд Үйлчлэх Төв хариуцна.

5. ХАВСРАЛТ:

Байхгүй

6. АНГИЛАЛ:

Захиргааны удирдамжийн гарын авлага

7. БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАРИУЦАХ ЭТГЭЭД:

Тэргүүн дэд ерөнхийлөгч, Өвчтөний санхүүгийн үйлчилгээний алба

8. ИШ ТАТСАН ЗҮЙЛ:

Дотоодоос

Гаднаас

Захиргааны удирдамжийн гарын авлага: Санхүүгийн туслалцааны бодлого Дотоод Орлогын Код 501(г) хэсэг

9. ШИНЭЧЛЭХ:

Байгууллага нь хуулийн хүрээнд энэхүү бодлогын нөхцөлийг дангаар шинэчлэх, засан залруулах, өөрчлөх, хянан сайжруулах эрхтэй байна.

10. БАТАЛСАН:

Brian M. Washa
Гарын үсэг

Sr. Vice President, Business Services
Албан тушаал

2/8/2022
Огноо

11. ОГНОО:

Анхны : 9/16

Хяналт : 2/22 Хүчинтэй хугацаа: 2/22

Дараагийн хяналт: 9/23

—